

**ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГИЙН  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
<b>Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"</b>							
1.	Оюуны өмчийн хязгаарлалттай бараанд тавих гаалийн хяналт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: -Оюуны өмчийн хяналтыг сайжруулах сургалтыг гаалийн газар, хороодын ГУБ нарт зохион байгуулсан байна. -Оюуны өмчийн хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.	1. Гаалийн ерөнхий газрын Хяналт, бүрдүүлэлтийн газар болон АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар, АНУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яамтай хамтарсан "Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг 2024 оны 04 сарын 25-ны өдөр зохион байгуулагдав. Тус сургалтад Зөрчилтэй тэмцэх газар, Эрсдлийн удирдлагын хэлтэс, Бүрдүүлэлтийн цахим төв, Мэдээллийн технологийн газар, Сургалтын төв, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, УБГГ, ЧХОУНБГГ, УХШИГГ, ГСГГ, СЭГГ, ДОГГ, ЗҮГГ, БӨГГ, ХОГГ-ын 35 албан хаагчдыг хамруулав. Энэхүү уламжлалт сургалт, хэлэлцүүлгийг Дэлхийн оюуны өмчийн өдөр болон Монгол Улсын оюуны өмчийг хамгаалах өдрийг тохиолдуулан жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулж байхаар тогтсон бөгөөд энэ удаагийн сургалт, хэлэлцүүлгээс эхлэн Гаалийн байгууллага хамтран оролцогч байгууллага болж байгаагаараа онцлог юм. 2. Сургалтын үр дүнг сайжруулах, гаалийн газар хороодод ажиллаж буй гаалийн улсын байцаагч нарыг гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд оюуны өмчийн эрхийг хамгаалж, хэрэгжүүлж ажиллах мэдлэг, чадвар олгох үүднээс дээрх сургалтыг газар хороодод дахин зохион байгуулан тайланг ирүүлэх талаар	01.02 06.05	100

					<p>албан бичиг хүргүүлж, мэдээллийг нэгтгэн удирдлагад танилцуулав.</p> <p>3. Оюуны өмчийн хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж ажилласан. Баянгол мед ХХК-ийн хүсэлтийн дагуу LPG барааны тэмдгийг гаалийн бүртгэлд бүртгүүлж хамгаалуулах тухай хүсэлтийг хүлээн авч хянан, гаалийн бүртгэлд авсан.</p> <p>4. Мэдээллийн технологийн газарт гаалийн үйлчилгээний цахим систем gaali.mn системийн үйлчилгээ цэсний Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргах, баталгаажуулах хэсгийг хэрэглээн нэвтрүүлж CAIS системд холбох холболт хийх тухай дотоод зурвасыг хүргүүлсэн.</p>		
2	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<p>Эхний хагас жилд: Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.</p>	<p>Сангийн яамнаас гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол шийдвэрийн хэрэгжилт, түүний биелэлтийн тайланг ирүүлж байхыг үүрэг болгосны дагуу тайланг сар бүрийн 05-ны өдрийн дотор хүргүүлж ажилласан. 2024 оны эхний хагас жилд 3 удаа хэрэгжилтийн тайланг дотоод зурваст заасан хугацаанд нь Хуулийн хэлтэст хүргүүлэн ажилласан.</p> <p>Хууль тогтоомж, эрхзүйн актын төсөлд санал боловсруулан хүргүүлж ажиллав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа зохион байгуулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмын төсөлтэй танилцаж, санал хүргүүлсэн</li> <li>-Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөртэй танилцаж, санал хүргүүлэв.</li> <li>-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн төсөлтэй танилцаж санал хүргүүлэв.</li> </ul>	01.02 06.05	100

3	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Эхний хагас жилд: -Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар ЭУХ-ээс зөвлөгөө, чиглэл авах ажлыг зохион байгуулсан байна.	<p>1. ГЕГ-ын даргын 2019 оны А/287 дугаар Журам батлах тухай тушаалын хавсралтаар батлагдсан Гаалийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмын хүрээд нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар судалж ажиллав.</p> <p>2. Тус журмын 5.1.1-д заасан Хяналт, бүрдүүлэлтийн нэгжийн гүйцэтгэх үүргийн хүрээнд гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд оюуны өмчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбогдон эрсдлийн мэдээллийг цуглуулах хүрээнд CAIS системд нэмэлт оруулахаах дараа хүсэлтийг хүргүүлсэн: Иргэн, аж ахуйн нэгж гаалийн байгууллагад бараагаа мэдүүлэх үед гаалийн мэдүүлгийн Барааны нэр, төрөл, БТКУС кодын мэдээллийг дээрх бүртгэлд хамрагдсан <b>барааны нэр, марк, зориулалт, үйлдвэрлэгч, оноосон нэр</b>-ийн мэдээлэлтэй тулган шалгагдаж, БТКУС кодоос гадна багадаа 1 мэдээлэл тохирч байвал бичиг баримтын шалгалт хариуцсан болон хяналт шалгалт хариуцсан албан хаагчид анхааруулга мэдээлэл өгөх</p> <p>3. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2023 оны 12 сарын 12-ны өдөр Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн гэрчилгээг Экспортын итгэмжлэлийн төрөлд авсан. “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-д заасан 8 хөнгөлөлтийг эдлэхэд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас тулгарч буй хүндрэлтэй 16 асуудлыг ирүүлж, тус асуудлууд үүсч буй шалтгаан нөхцлийг тогтоох, шийдвэрлэх арга зам олох зорилгоор нэгбүрчлэн хэлэлцэж, хамтран ажиллах, харилцан ойлголцох зорилгоор зохион байгуулсан уулзалтад 2024 оны 06 сарын 03-ны өдөр оролцсон.</p> <p>4. Гаалийн байгууллагын дэд дарга, бүтцийн нэгжийн дарга нар Стандарт, хэмжил зүйн газрын удирдлагууд оролцсон хамтарсан уулзалтыг зохион байгуулж, уулзалтаас гарсан</p>	01.02 06.05	100
---	--	-------------------------	---	--	----------------	-----

					шийдвэрийн дагуу гаалийн байгууллага хэрэгжүүлэн ажилладаг стандартуудыг үнэгүй авахаар жагсаалтыг холбогдох нэгжүүдээс гаргуулан Стандарт, хэмжил зүйн газарт албан бичгээр хүргүүлсэн.		
4	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	<p>1.Засгийн газрын 2023 оны 445 дугаар Журам, жагсаалт, үнийн дүн батлах тухай тогтоол, Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн НӨАТ-ын буцаан олголттой холбоотойгоор тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус ажлын хэсгийн viber группт нэгдэн, өдөр тутмын мэдээлэлтэй танилцан, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажилд санал хүргүүлэн, гаалийн байгууллагын оролцоог ханган ажиллаж байна.</p> <p>2. Зорчигчийн мэдээллийн төвийн дарга Энхтөр болон Гаалийн ерөнхий газрын холбогдох нэгжийн удирдлагуудын уулзалт 2024 оны 02 сарын 19-ний өдөр зохион байгуулав.</p> <p>3.Хяналтын тэмдэг захиалгыг гаалийн газар, хороодоос хүлээн авч шинээр үйлдвэрлүүлэн СХОГ-т хүргүүлэв.</p> <p>4. Гаалийн ерөнхий газрын дэд дарга “Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт хийх баг”-ийн бүрэлдэхүүн, удирдамжийг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан удмрдамжийн дагуу Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цэндсүрэнгээр ахлуулсан судалгааны багт ажилласан. Хэрэгжилт:  <input type="checkbox"/> Судалгааны ажил нь Хураангуй, Судалгааны арга зүй, Онол, арга зүйн үндэслэл, Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн байдал, Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа, Дүгнэлт, Санал, Хавсралтыг оролцуулсан долоон бүлэг, зургаан дэд бүлэг,</p>	01.02 06.05	100

					<p>долоон дэд хэсэг, 17 зураг, 40 хүснэгт, 5 хавсралтаас бүрдэнэ (80 хуудастай). Бүрдүүлэлтийн цаг хугацааны өмнөх таван судалгаа, 2019, 2022, 2023 оны судалгаанд хамрагдсан хугацаанд хийгдсэн 17,352 гаалийн мэдүүлэг ба 100,152 барааны бичлэгт хамаарах, таван дэд программаас авсан давхардсан тоогоор 18 төрлийн 266,309 мянган өгөгдөл/мэдээллийг судалгаанд хамруулсан.</p> <p>□ Эхний бүлэгт бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх онол, арга зүйн үндэслэлийг ДХБ, ДГБ, бусад олон улсын байгууллага болон Монголын Гаалийн байгууллагаас өмнө хийсэн судалгааг бусад орны туршлагыг харьцуулан судлах замаар гаргасан.</p> <p>□ Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын 2018-2022 он, 2023 оны гадаад худалдааны гүйцэтгэл, өсөлт, бууралтын хувь, импорт, экспортын барааны бүтцийг харьцуулан судалж, гадаад худалдааны өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлагыг харуулсан.</p> <p>□ Гуравдугаар бүлэгт сонгон авсан хугацаанд гаалийн газар, хяналтын бүсэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээллийг КАИС-ийн таван дэд программаас татан авч, харьцуулан, хилийн гааль дээр, хилээс гүний гаалийн хяналтад илгээн, барааг эзэнд олгох хүртэлх цаг хугацааг тооцоолон, өмнөх судалгаатай харьцуулан цаг хугацааны өөрчлөлтийг гаргасан.</p> <p>□ Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой долоон төрлийн үйл ажиллагааг ажиглагдсан утга тус бүрээр Статистикийн “Дундаж, Медиан, Хамгийн их, Хамгийн бага утга, Стандарт хазайлт, Хазайлт, Муруйлт, Нийлбэр” утгаар шинжилгээ хийсэн.</p> <p>□ Төгсгөлийн бүлэгт судалгааны ажлыг нэгтгэн, гаалийн хяналтын эрсдэл, эрсдэлийн удирдлагын онолын үндэслэл, аргачлал, олон улсын туршлагад тулгуурлан гаалийн хяналтын эрсдэлийг бууруулах боломж, хэрэгжүүлэх арга</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>замыг тодорхойлон эрсдэлийн шалгуурын хувь хэмжээг тогтоож судлан холбогдох санал зөвлөмжийн хамт судалгааны ажлыг дүгнэсэн.</p> <p>□ Гаалийн байгууллагын мэдээллийн автоматжуулсан системд 2023 оноос шинэчлэл хийгдэж тээврийн хэрэгслийн программд автотээврийн хэрэгслээс гадна агаарын тээврийн хэрэгсэл, төмөр замын тээврийн хэрэгслээр орсон барааны бүртгэл бүрэн хэмжээгээр хийдэг болсон. Энэ нь өмнө нь асуулгын хуудсаар ачилт бүрийн хугацааг тэмдэглэн, дахин хөрвүүлж байсантай харьцуулахад томоохон ахиц дэвшил гарсан гэж үзэж байна.</p> <p>Хүрсэн түвшин:</p> <p>□ Судалгааны тайланг ГЕГ-ын дарга, дэд даргад танилцуулж, 2024.05.13-ны өдрийн онлайн хуралд танилцуулж, ЗДАСП-ын Худалдааг хөнгөвчлөх дэд талбарт байршуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан (хандалтын тоо: 190).</p> <p>□ ГЕГ-ын 2019 оны Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаатай 2023 оны судалгааг сонгон авсан гаалийн газар, хороодоор харьцуулахад “Тээвэрлэлт, Татвар төлөх хугацаа, Хорио цээрийн шалгалт, Гаалийн лабораторийн шинжилгээ” зэрэг үйл ажиллагаа бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлжээ.</p> <p>□ Тээвэрлэлтийн хугацааг оруулахгүйгээр 2023 оны бүрдүүлэлтийг 2022 оны мөн үетэй харьцуулахад хорио цээрийн шалгалтад зарцуулсан дундаж хугацаа 16 хувь өсч, бусад үе шат 3-177 хувиар тус тус буурсан байна. Нийт бүрдүүлэлтийн хугацаа нь 9 хувиар буурсан.</p> <p>□ ГЕГ-аас бичиг баримтын бүрдүүлэлтийг төвлөрүүлэн хийж, бүрдүүлэлтэд хавсаргасан цахим бичиг баримтаар бичиг баримтын шалгалт хийх болсноор бичиг баримтын шалгалтад зарцуулах дундаж цаг хугацаа</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>ажиглагдсан утгын хувьд 177 хувиар буурсан үр дүнд хүрчээ.</p> <p>□ “Татвар төлөх хугацаа” нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ба 2022 оны дунджаар 20 цаг, 19 минут; 2023 оны дунджаар 19 цаг 38 минут тус тус зарцуулсан. “Татвар төлөх хугацаа” нь гаалийн бүрдүүлэлтийн хугацааг нэмэгдүүлсэн байна. Учир нь гаалийн байгууллагаас шалтгаалахгүй мэдүүлэгч нар бараагаа авахгүй удаж байгаа нь улаан төлөвт ХШ-ын ГУБ, улбар шар, ногоон төлөвт ХШ-ын ГУАБ, цаашлаад нийт хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.</p> <p>□ Гаалийн хяналтын улбар шар болон ногоон төлөвт сонгогдсон гаалийн бүрдүүлэлтийн хугацаа улаан төлөвтэй бараг ойролцоо гарсан нь “Татвар төлөх хугацаа” өндөр байгаатай холбоотой, нөгөөтэйгүүр барааны тоогоор харьцуулахад нэг болон олон нэр төрөлтэй эсэхээс үл хамаарч бичиг баримт болон бараанд хийх шалгалтад ижил хугацаа, эсхүл нэг нэр төрлийн бараанд илүү хугацаа зарцуулжээ.</p> <p>Цаашид:</p> <p>□ Гаалийн бүрдүүлэлт, Эрсдэлийн удирдлага, Зөрчил, Гаалийн лаборатори болон Тээврийн хэрэгсэл, Манифест, Пүүний программ хангамжийн мэдээллийг хооронд нь уялдуулж, хяналтын үе шат бүрийг “Гаалийн бүрдүүлэлтийн хугацаа” дэд талбарт үнэн зөв, нэг цонхоор харах боломжийг нэн даруй бүрдүүлэх;</p> <p>□ Гаалийн хяналтын үе шат бүрээр (Бичиг баримт, Хорио цээр, Хяналт шалгалт) цаг хугацааны стандартыг тээврийн хэрэгслийн төрөл, барааны тоо хэмжээ, хяналт шалгалтын арга, гаалийн хяналтын төлөвтэй уялдуулан стандарт боловсруулах ажлын хэсэг гарган, гаалийн газар, хороод, чиглэл хариуцсан албаны дарга, ГУАБ, ГУБ нарын ажлын гүйцэтгэлтэй уялдуулах зөвлөмж гаргахаар</p>		
--	--	--	--	--	--	--	--

					төлөвлөж байна. зорилгоор 2022 оны мөн үеийн бүрдүүлэлттэй харьцуулан судалсан.		
5	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	-Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ.	2024.06.05-ны өдрийн байдлаар ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн. 2024 онд: -томилолтоор ажиллах 1; -уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 2; -хурлын өрөөний 1 буюу нийт 4 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан.	01.02 06.05	100

**Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
<b>“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>					
1.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	ОУВС-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн Томас Хансены “Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник” сэдвээр 2024.04.08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан семинарт оролцсон.	04.08 04.10	100
2.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	АНУ-ын Нью Йорк мужийн Зүүн Дүүргийн Шүүх, Аюулгүй байдлын мөрдөн шалгах алба, Патент, Барааны тэмдэгийн газрын Олон улсын харилцаа, бодлогын албаны ажилтанууд, АНУ-ын ЭСЯ, Оюуны өмчийн газар, ГЕГ-аас хамтран албан хаагч нарыг чадавхижуулах “Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт” сэдвээр зохион байгуулагдсан цахим орчин дахь эрхийн зөрчил, хуурамч барааг онолох, таних сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр оролцсон.	04.25	100

3.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	БНХАУ-ын Худалдааны яамнаас Шаньдун мужийн Чиндао хотноо зохион байгуулсан “Монголын цахим худалдааны 14 хоногийн семинар”-т Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/172 дугаар тушаалын дагуу 5 албан хаагчийн нэг болж мөн Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг 5 байгууллагын төлөөлөл болох нийт 21 албан хаагч оролцсон.	03.20 04.03	100
4.	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, “Glossary of international trade and customs terms”-ыг судалсан байна.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор “Glossary of international trade and customs terms”-ыг судалж байна.	01.02 06.05	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН

УЛСЫН БАЙЦААГЧ

*Юинбилэг*

/Н.ОЙНБИЛЭГ/ 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

80

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар  
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

**1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
<b>Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт</b>					
1	Оюуны өмчийн хязгаарлалттай бараанд тавих гаалийн хяналт.	55	7	62	
2	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	55	7	62	
3	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	50	6	56	
4	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлт	60	10	70	
5	Ажлын цаг ашиглалт.	57	8	65	
<b>Дундаж оноо</b>				<b>63</b>	

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	100	15	
2.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	100	15	
3.	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	90	12	
<b>Дундаж оноо</b>			<b>14</b>	

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)**

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	

5.	Ажлын цаг ашиглалт	7	6.6
<b>Дундаж оноо</b>			

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)**

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
<b>Дундаж оноо</b>		


**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)	63
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
<p style="text-align: center;"><b>Нийт оноо =</b></p> <p>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо</p>		91.6

**Үнэлгээ өгсөн:**

**Нэгжийн дарга:**

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
(албан тушаал)



..... (Б.Даваасүрэн)  
..... 2024.06.10 .....(огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

Гаалийн улсын байцаагч  
(албан тушаал)


..... (Н.Ойнбилэг)  
..... 2024.06.10 .....(огноо)

**Үнэлгээг хянасан :**

**Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

Дэд даргын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч  
(албан тушаал)

  
.....  
(гарын үсэг)

(Г.Энхтайван)  
2024.07.26 (огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**  
Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч

.....  
(албан тушаал)

  
.....  
(гарын үсэг)

(Ж.Баясгалан)  
..... (огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:**

Гаалийн ерөнхий газрын дарга  
(албан тушаал)



**Төсвийн шууд захирагч**

.....  
(гарын үсэг)

(Р.Отгонжаргал)  
..... (огноо)